



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УСНЫ ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/20/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага.....	12
3.5.3 Урьдчилгаа	13
3.5.4 Бараа материал	13
3.5.5 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.6 Өр төлбөр.....	14
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.8 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	
/мянган төгрөгөөр/	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СГЗ	Сав газрын захиргаа
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



УСНЫ ГАЗРЫН ДАРГА
Ш.МЯГМАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/700

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Усны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Монгол Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө нь 2014-2021 онд хэрэгжиж дууссан ба уг төлөвлөгөөний гүйцэтгэл, хүрсэн үр дүнг дүгнэж, дараагийн менежментийн төлөвлөгөөг "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулах шаардлага байна.

Аудитын гол асуудлууд

Аудитаар илэрсэн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, сургалт, семинар танхимаар зохион байгуулсан, хөрөнгө орлогод аваагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон 98.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 42 дугаар зүйлийн 42.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудал

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын усны талаар авч хэрэгжүүлэх хамгийн эхний үйл ажиллагааг “Усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчмыг тогтоож, ус ашиглалтыг төлбөртэй болгон хэмнэлттэй хэрэглээ, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх” гэж тодорхойлсон боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан чөлөөлөлтийн дагуу хоногт 100 шоо метрээс их ус ашиглагч байгууллагууд 2019 онд 2.8 сая м3, 2020 онд 2.8 сая м3, 2021 онд 2.9 сая м3 усыг үнэ төлбөргүй ашигласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	801,149.1	888,597.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,000.0
33	АВЛАГА	7,930.9	7,940.3
34	УРЬДЧИЛГАА	549,400.0	556,800.0
35	БАРАА МАТЕРИАЛ	243,818.2	321,856.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,846,237.7	6,855,858.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,846,237.7	6,855,858.8
39200	Биет хөрөнгө	3,766,993.4	4,564,884.4
39300	Биет бус хөрөнгө	79,244.3	2,290,974.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,647,386.8	7,744,455.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,118.9	1,502.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,118.9	1,502.4
41300	Өглөг	15,118.9	1,502.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,632,267.9	7,742,953.5
51	Засгийн газрын хувь оролцоо	4,632,267.9	7,742,953.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,975.2	543,975.2
51200	Хуримтлагдсан үр дүн	4,088,292.7	7,179,538.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	19,440.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,647,386.8	7,744,455.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,916,642.9	9,658,934.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	457,199.8	3,858,166.5
120	Нийтлэг татварын бус орлого	457,199.8	3,858,166.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,459,443.1	5,800,768.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,090,272.4	6,577,453.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,090,272.4	6,567,475.8
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,345,105.0	5,754,677.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,506,556.6	2,740,437.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,750.9	368,880.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,213.0	216,642.4
2104	Хангамж, бараа материалын зардал	327,975.4	288,703.7
2105	Нормативт зардал	15,842.6	6,523.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,133.9	128,807.0
2107	Томилолт, зочны зардал	123,393.2	136,955.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,811.9	1,026,226.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	559,427.5	841,499.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	745,167.4	812,798.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,977.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(173,629.5)	3,081,481.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,895.2	4,684.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(181,524.7)	3,076,796.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,722,906.7	6,063,725.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,527.8	262,957.9
120	Нийтлэг татварын бус орлого	17,527.8	262,957.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,705,378.9	5,800,768.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,675,110.0	5,849,696.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,675,110.0	5,849,696.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,930,062.9	5,036,897.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,433,267.1	2,722,205.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327,397.3	369,304.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,344.2	217,192.6
2104	Хангамж, бараа материалын зардал	336,465.4	284,607.0
2105	Нормативт зардал	17,468.0	10,015.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,098.0	120,568.4
2107	Томилолт, зочны зардал	115,034.4	143,547.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,940.6	1,110,694.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,047.9	58,762.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	745,047.0	812,798.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	47,796.7	214,029.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,796.7	212,029.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,796.7	212,029.2
2200	Дотоод эх үүсвэрээр	47,796.7	212,029.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(47,796.7)	(212,029.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	2,000.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,000.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,557,898.5	4,557,898.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,027.8)	(2,027.8)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,555,870.7	4,555,870.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	257,921.9	257,921.9
9	Тайлант үеийн үр дүн	(181,524.7)	(181,524.7)
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,632,267.9	4,632,267.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	14,448.8	14,448.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,646,716.7	4,646,716.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	19,440.0	19,440.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	3,076,796.8	3,076,796.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,742,953.5	7,742,953.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,943,721.5	4,622,315.5	321,406.0	93.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,943,721.5	4,622,315.5	321,406.0	93.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,764,309.6	4,462,084.8	302,224.8	93.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,931,429.7	2,721,995.0	209,434.7	92.9
210101	Үндсэн цалин	2,113,498.1	1,970,213.0	143,285.1	93.2
210102	Нэмэгдэл	575,956.1	549,323.3	26,632.8	95.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	241,975.5	202,458.7	39,516.8	83.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	397,654.5	369,304.8	28,349.7	92.9
210201	Тэтгэврийн даатгал	280,123.2	259,797.1	20,326.1	92.7
210202	Тэтгэмжийн даатгал	29,382.8	27,928.4	1,454.4	95.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,506.7	22,079.7	1,427.0	93.9
210204	Ажилгүйдлийн даатгал	5,876.4	5,428.0	448.4	92.4
210205	Эрүүл мэндийн даатгал	58,765.4	54,071.6	4,693.8	92.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,676.2	217,192.6	27,483.6	88.8
210301	Гэрэл, цахилгаан	41,671.9	23,616.9	18,055.0	56.7
210302	Түлш, халаалт	53,138.9	42,938.5	10,200.4	80.8
210303	Цэвэр, бохир ус	2,041.4	1,957.4	84.0	95.9
210304	Байрны түрээс	147,824.0	148,679.8	(855.8)	100.6
2104	Хангамж, бараа материалын зардал	184,904.9	181,237.1	3,667.8	98.0
210401	Бичиг хэрэг	26,029.3	27,154.8	(1,125.5)	104.3
210402	Тээвэр, шатахуун	94,433.2	94,571.0	(137.8)	100.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,078.1	35,306.6	4,771.5	88.1
210404	Ном, хэвлэл	-	13.5	(13.5)	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	86.6	86.0	0.6	99.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,277.7	24,105.2	172.5	99.3
2105	Нормативт зардал	10,493.7	10,135.7	358.0	96.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,493.7	10,135.7	358.0	96.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,664.9	87,488.4	3,176.5	96.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,513.0	18,318.9	194.1	99.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,579.6	10,450.1	129.5	98.8
210604	Урсгал засвар	61,572.3	58,719.4	2,852.9	95.4
2107	Томилолт, зочны зардал	77,463.4	69,870.3	7,593.1	90.2
210702	Дотоод албан томилолт	77,463.4	69,870.3	7,593.1	90.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	799,839.0	777,692.9	22,146.1	97.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	766,474.8	749,678.6	16,796.2	97.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,393.0	3,402.5	990.5	77.5
210803	Даатгалын үйлчилгээ	8,497.7	7,740.6	757.1	91.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,246.9	1,387.7	859.2	61.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,018.6	746.0	272.6	73.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,383.0	14,259.9	2,123.1	87.0
210807	Газрын төлбөр	429.0	81.6	347.4	19.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	396.0	396.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,183.3	27,168.0	15.3	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800.0	800.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,383.3	26,368.0	15.3	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	179,411.9	160,230.7	19,181.2	89.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	179,411.9	160,230.7	19,181.2	89.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,560.1	2,560.1	-	100.0

Усны газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	176,851.8	157,670.6	19,181.2	89.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,943,721.5	4,622,315.5	321,406.0	93.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,933,721.5	4,362,357.6	571,363.9	88.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,933,721.5	4,362,357.6	571,363.9	88.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000.0	259,957.9	(249,957.9)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000.0	258,807.9	(248,807.9)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,150.0	(1,150.0)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	498	490	8	98.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	22	22	0	100.0
610001	Төсвийн байгууллага	22	22	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	238	234	4	98.3
620001	Удирдах ажилтан	27	27	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	183	178	5	97.3
620003	Үйлчлэх ажилтан	28	28	0	100.0
620004	Гэрээт ажилтан	0	1	-1	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	238	234	4	98.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	206	200	6	97.1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	32	34	-2	106.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/мянган төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	798,775.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	791,775.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	710,570.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	210.0
2104	Хангамж, бараа материалын зардал	104,203.5
210401	Бичиг хэрэг	6,549.0
210402	Тээвэр, шатахуун	78,129.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,262.7
210404	Ном, хэвлэл	1,600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,662.7
2105	Нормативт зардал	165.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	165.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,245.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,310.3
210604	Урсгал засвар	47,935.0
2107	Томилолт, зочны зардал	73,677.1
210702	Дотоод албан томилолт	73,677.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	398,362.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,042.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,707.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,407.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,204.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,674.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,674.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	65,529.8
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	65,529.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	7,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	798,775.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	798,775.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	88,969.4
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,424.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,851.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	680,530.2

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Усны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэн ус ашиглуулах дүгнэлт гаргасан үйлчилгээний орлогыг аккрузал сууриар бүртгэх, харьяа байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 05-наас 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Г.Мөнхчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Усны газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 01/202 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Усны газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Чадварлаг хүний нөөц байгальд ээлтэй тэргүүлэх техник, технологиор ус хангамж ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

- Тэсвэртэй байдал
- Инновац бүхий дэд бүтэц
- Тогтвортой үйл ажиллагаа
- Ногоон хөгжил
- Тогтвортой эдийн засаг
- Уян хатан хүний хөгжил

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Усны газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлдэг ба тайлант онд аудит хийгээгүй байна.

Усны газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

Байгууллагын дарга Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ, ерөнхий нягтлан бодогч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар хувиар буюу 98.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2.0 сая төгрөг байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	0.0	2,000.0	2,000.0
Дүн	0.0	2,000.0	2,000.0

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.0 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний болон эцсийн үлдэгдэл 7.9 сая төгрөг байгаа нь өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	348.7	116.8	-231.9
Татвар, НДШ авлага	206.7	0.0	-206.7
Байгууллагаас авах авлага	6,172.8	6,620.8	448.0
Хувь хүмүүсээс авах авлага	1,202.7	1,202.7	0.0
Дүн	7,930.9	7,940.3	9.4

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Усны газрын төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын таваас дээш жилийн насжилттай 7.9 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- Ажиллагчидтай холбогдсон цалингийн авлагад Хяргас нуур, Завхан голын СГЗ, Идэр голын СГЗ, Алтайн өвөр говийн СГЗ, Хэрлэн голын СГЗ-ны, нийт 0.1 сая төгрөг;

- Байгууллагаас авах авлагад Онон улз голын СГЗ-ны 3.4 сая төгрөг, Хяргас нуур Завхан голын СГЗ-ны 0.5 сая төгрөг, Хөвсгөл нуур Эгийн голын СГЗ-ны 0.6 сая төгрөг, Сэлэнгэ голын СГЗ-ны 2.1 сая төгрөг, нийт 6.6 сая төгрөг;
- Хувь хүмүүсээс авах авлагад Хяргас нуур Завхан голын СГЗ-ны 1.2 сая төгрөг.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 549.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 556.8 сая төгрөг болж, өмнөх оныхоос 7.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.3 Урьдчилгаа /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	548,800.0	556,800.0	8,000.0
Томилолтын урьдчилгаа	600.0	0	-600.0
Дүн	549,400.0	556,800.0	7,400.0

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Туул голын СГЗ-ын Төв цэвэрлэх байгууламжийн хаягдал бохир усыг био технологийн аргаар цэвэршүүлэх ажлын урьдчилгаа болох 548.8 сая төгрөг, Бөөн цагаан нуур Орог голын СГЗ-ын ажлын урьдчилгаа 8.0 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 243.8 сая, эцсийн үлдэгдэл 321.8 сая төгрөг болж, өмнөх оныхоос 78.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.4 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	75,444.7	94,327.2	18,882.5
Бичиг хэргийн материал	18,964.9	20,369.6	1,404.7
Аж ахуйн материал	98,117.8	143,877.4	45,759.6
Сэлбэг хэрэгсэл	11,819.6	14,447.8	2,628.5
Түлш шатах тослох материал	15,833.0	20,612.9	4,779.9
Бусад хангамжийн материал	23,638.3	28,221.8	4,583.5
Дүн	243,818.2	321,856.8	78,038.6

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 440.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 363.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан, Усны газар болон Сав газруудын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,846.2 сая, эцсийн үлдэгдэл 6,855.8 сая төгрөг болж, 3,009.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2,058,203.5	2,986,791.3	928,587.8
Тээврийн хэрэгсэл	340,940.8	482,234.9	141,294.1
Машин тоног төхөөрөмж	1,239,690.5	970,657.2	-269,033.3
Тавилга эд хогшил	119,121.6	117,591.4	-1,530.2
Ном	269.3	269.3	0.0
Бусад үндсэн хөрөнгө	8,767.6	7,340.3	-1,427.3
Программ хангамж	2,302.8	2,032.9	-269.9
Бусад биет бус хөрөнгө	76,941.5	2,518,922.8	2,441,981.3

Дүн	3,846,237.7	7,085,840.1	3,239,602.4
------------	--------------------	--------------------	--------------------

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгө 202.1 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 3,385.7 сая төгрөг, хандивын 53.8 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 47.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 176.5 сая төгрөг, шилжүүлсэн хөрөнгө 5.1 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 228.8 сая, бусад байдлаар 269.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1.5 сая төгрөг болж, 13.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	15,118.9	1,502.4	-13,616.5
Ажилчидтай холбогдсон өглөг	2,591.7	1,244.6	-1,347.4
Бусад өглөг	12,527.2	258.1	-12,269.1
Нийт дүн	15,118.9	1,502.4	-13,616.5

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Онон улз голын СГЗ 1.0 сая, Хар нуур Ховд голын СГЗ 0.1 сая, бусад СГЗ 0.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,632.3 сая, эцсийн үлдэгдэл 7,742.9 сая төгрөг болж, 3,110.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	543,975.2	543,975.2	0.0
Хуримтлагдсан үр дүн	4,088,292.7	7,409,519.5	3,321.2
Өмнөх үеийн үр дүн	4,269,817.4	4,102,741.5	-167,075.9
Тайлант үеийн үр дүн	-181.5	3,306,778.1	3,306,959.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.0	19,440.0	19,440.0
Нийт дүн	4,632,267.9	7,972,934.7	3,340,666.8

Эх сурвалж: Усны газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,078.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 7,078.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 2,134.3 сая төгрөгөөр бууруулж, 4,943.7 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын нөлөөллөөс шалтгаалан бараа, үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

Төсвийн орлого бүрдүүлэлт

Усны газар тайлант онд 10.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 258.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 248.8 сая төгрөгөөр илүү биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	10.0	258,807.9	248,807.9	2,588.0
Нийт дүн	10.0	258,807.9	248,807.9	2,588.0

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 248.8 сая төгрөгөөр давсан нь Усны газрын ус ашиглуулах дүгнэлтийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээнд зориулан 4,943.7 сая төгрөгийн төсөв баталснаас урсгал зардалд 4,622.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зардлын 4,933.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн олгосон ба урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 571.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Усны газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх зарим зардлуудыг дутуу зарцуулсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Усны газрын баталсан 38 орон тооноос 35-36 албан хаагч ажилласан, мөн Сав газрын захиргаад дутуу орон тоогоор ажилласнаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 209.4 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Дээрх цалингийн хэмнэлтээс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 12.5 хувийг Сангийн яамнаас 13.5 хувиар төсөвлөснөөс Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 28.3 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Усны газрын 2021 оны 1-3 сарын байр ашиглалттай холбоотой зардлыг Туул голын СГЗ төлснөөс Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27.5 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Усны газрын урсгал засварын зардлаас 3.1 сая төгрөг хэмнэсэн;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 22.1 сая төгрөг хэмнэсэн. /Онон Улз голын СГЗ 7.8 сая төгрөг, Онги Таац голын СГЗ 0.8 сая төгрөг, Увс нуур Тэсийн голын СГЗ 0.2 сая төгрөг, Сэлэнгэ голын СГЗ 10.4 сая төгрөг, Туул голын СГЗ 0.4 сая төгрөг, Усны газар 2.5 сая төгрөг/;
- Туул голын СГЗ-аас 2022 онд тэтгэвэрт гарах ажилтны тэтгэмжийг тайлант онд төлөвлөснөөс Урсгал шилжүүлэг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 19.2 сая төгрөгөөр хэмнэсэн.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд хандив, тусламжаар 89.0 сая төгрөг, Засгийн газрын нөөц сангаас 2.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 26.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 680.5 сая төгрөг, нийт 798.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 710.6 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 15.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 7.0 сая төгрөг, нийт 733.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 65.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан д 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Усны газрын харьяа байгууллагууд тайлант онд нийт 3,322 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 3,117 мэдээллийг хугацаанд нь, 100 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 105 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хүрэх үр дүнг нарийвчлан шалгах, орлого бүрдүүлэлт, гүйцэтгэлийг харилцагч байгууллага нэг бүртэй тулган баталгаажуулах, хамаарал бүхий төрийн байгууллагуудтай үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулж сайжруулсан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 22 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэхээс 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамруулсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 20, “Хязгаарлалттай” 1 /Хэрлэн голын сав газрын захиргаа/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 463.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 167.5 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 2.9 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 282.7 сая төгрөгийн 16 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй 296.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 98.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 194.2 сая төгрөгийн 44 алдаа, зөрчил илрүүлснээс 167.5 сая төгрөгийн 15 алдааг аудитын явцад залруулж, 2.9 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13.2 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага, 10.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 13 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.9.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

Олон Улсын усны конвенц, хөрш орны хил дамнасан усны нөөцийн бодлого, Засгийн газар хоорондын хэлэлцээр зэргийг судлалгүйгээр төсөл, арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл гарсан нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйл Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага 27.1.2 “макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс 2,588 хувийн орлогын гүйцэтгэл гарсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.1 төсвийн тогтвортой байдлыг хангасан байх; 5.1.2 төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх; 5.1.5 хариуцлагатай байх гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төсөл боловсруулах, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө макро эдийн засгийн төлөв байдал, судалгаа, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэж байх талаар албан шаардлага өгөв.

Газрын доорх усны хяналт, шинжилгээний сүлжээг өргөтгөх нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээнд зориулан 80.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, угсарч суурилуулах ажил хийсэн боловч хөрөнгийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ; 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Одоо ашиглаж байгаа бүртгэлгүй үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлж, бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөв.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчин 62.6 сая төгрөгийн сургалт, семинарыг танхимаар зохион байгуулсан нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

Урсгал төсвөөс 126.8 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; 42 дугаар зүйлийн 42.7 “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

Ус ашигласны төлбөрийн тооцоог хянах нарийвчилсан дотоод хяналтын журамгүй, тооцоолох цахим системгүй, мэргэжилтнүүдийн тооцоолол дээр үндэслэж байгаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 “Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг

журам"-д нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" боловсруулан батлах, ус ашигласны төлбөрийг тооцоолох цахим системтэй болох талаар албан шаардлага өгөв.

3.9.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ус ашиглуулах дүгнэлт гаргасан үйлчилгээний орлогыг мөнгөн сууриар бүртгэж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 "нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурь" гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг; 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ус ашиглуулах дүгнэлт гаргасан үйлчилгээний орлогыг аккрузал сууриар бүртгэж байх.

Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа Хэрлэн голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан хязгаарлалттай дүгнэлт авсан ба харьяа 21 байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 194.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 167.5 сая төгрөгийн 15 алдааг залруулж, 2.9 сая төгрөгийн зөрчилд 5 акт тогтоож, 13.2 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 10.6 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмж: "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д харьяа байгууллагуудад хяналт хэрэгжүүлэх арга, аргачлал, хуваарийг тодорхой тусгаж, дотоод хяналтын үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын удирдлага батлан, гүйцэтгэлийг үнэлүүлж хэвших, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Аудитын санал дүгнэлт		Алдаа зөрчлийн ангилал								Нийт алдаа, зөрчлийн дүн	
		Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга			
		Зөрчилгүй	Хязгаарлалттай										
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Усны газар		1			5	269,538.4	2				7	269,538.4
2	Туул голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	1	-	0	-	1	-
3	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	1	1,737.9	3	25,751.2	4	27,489.1
4	Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	1	-	0	-	1	-
5	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	1		-	-	1	-	1	415.0	1	268.2	3	683.2
6	Хараа-Ерөө голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	0	-	0	-	0	-
7	Онги-Таац голын сав газрын захиргаа	1		-	-	1	640.0	1	-	0	-	2	640.0
8	Онон-Улз голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	1	-	1	17,500.0	2	17,500.0
9	Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа	1		-	-	0	-	0	-	1	6,987.0	1	6,987.0
10	Орхон-Чулуут голын сав газрын захиргаа	1		0	-	0	-	0	-	0	-	0	-
11	Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа	1		0	-	0	-	0	-	1	500.0	1	500.0
12	Бөөнцагаан нуур-Орог нуурын сав газрын захиргаа	1		1	1,239.9	0	-	1	-	2	8,323.7	4	9,563.6

Усны газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

13	Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа	1		0	-	3	3,300.0	0	-	0	-	3	3,300.0
14	Хэрлэн голын сав газрын захиргаа		1	1	610.0	3	6,000.0	0	-	1	1,100.0	5	7,710.0
15	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа	1		1	-	1	1,956.5	2	957.2	0	-	4	2,913.7
16	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	1		0	-	0	-	2	-	3	54,477.3	5	54,477.3
17	Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа	1		0	-	0	-	1	-	1	51,800.0	2	51,800.0
18	Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргаа	1		0	-	0	-	0	-	1	800.0	1	800.0
19	Хануй голын сав газрын захиргаа	1		0	-	0	-	0	-	0	-	0	-
20	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	1		0	-	0	-	1	7,500.0	0	-	1	7,500.0
21	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа	1		2	1,063.0	2	1,331.4	0	-	0	-	4	2,394.4
22	Идэр голын сав газрын захиргаа	1				0	-	0	-	0	-	0	-
Дүн		20	2	5	2,912.9	16	282,766.3	15	10,610.1	15	167,507.4	51	463,796.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 678/А0160056

Улаанбаатар хот

АХГ-2022/20/НА-СТА-Т13

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 62,580,750.00 төгрөгийн сургалт, семинарыг танхимаар зохион байгуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг зөрчин, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга Ш.Мягмар, нягтлан бодогч Ш.Ганзориг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ

Г ГҮНЖИДМАА

А ДАВААДОРЖ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-305.Docx

0001331641



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 01 дугаар сарын 25 № 681/А0160056

Улаанбаатар хот

АХГ-2022/20/НА - СТА-ТЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээг өргөтгөх нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээнд зориулан 80,100,000.00 төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, угсарч суурилуулах ажил хийсэн боловч хөрөнгийг орлогод аваагүй шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ;" 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Одоо ашиглаж байгаа бүртгэлгүй үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлж, бүртгэлд тусгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга Ш.Мягмар, нягтлан бодогч Ш.Ганзориг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ГҮНЖИДМАА

А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-304.Docx

0001221629



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 682/АД/60056

Улаанбаатар хот

АХГ-2022/20/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урсгал төсвөөс 126,857,696.00 төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; 42 дугаар зүйлийн 42.7 “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга Ш.Мягмар, нягтлан бодогч Ш.Ганзориг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ГҮНЖИДМАА

А.ДАВААДОРЖ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-306.Docx

0001081643



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 683/АБ/60056

Улаанбаатар хот

АХГ - 2022/20/НА-СТА-Т13

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ус ашигласны төлбөрийн тооцоог хянах нарийвчилсан дотоод хяналтын журамгүй, тооцоолох цахим системгүй, мэргэжилтнүүдийн тооцоолол дээр үндэслэх байна.

Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 "Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" боловсруулан батлах, ус ашигласны төлбөрийг тооцоолох цахим системтэй болох, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Усны газрын дарга Ш.Мягмар, нягтлан бодогч Ш.Ганзориг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ГҮНЖИДМАА

А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shoardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-307.Docx

0001081645

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]